

**“БАРИЛГА, ОРОН СУУЦ, ГУДАМЖ ТАЛБАЙД ТАВИХ ХЯНАЛТЫН КАМЕР.  
ЕРӨНХИЙ ШААРДЛАГА MNS 6423:2013” СТАНДАРТЫГ ШИНЭЧЛЭН  
БОЛОВСРУУЛАХ АЖЛЫН ДААЛГАВАР**

<p>Боловсруулах үндэслэл, хэрэгцээ, шаардлага</p>	<p>Тус стандарт нь 2013 онд батлагдсан бөгөөд тухайн үед ашиглагдаж байсан хяналтын камерын дундаж техникийн үзүүлэлтүүдээр стандарт шаардлагуудыг тогтоосон.</p> <p>Гэвч техник технологийн хурдацтай хөгжлийн дүнд орчин үеийн хяналтын камеруудын техникийн үзүүлэлт хэд дахин сайжирсан бөгөөд гудамж талбайн телехяналтын системийг MNS 6423:2013 стандартаар тогтоосон техникийн үзүүлэлтийн дагуу суурилуулж байгаа нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх, таслан зогсоох, нийтийн хэв журмыг сахин хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны ашиглалтын шаардлагыг хангахгүй, тухайлбал, камерын дүрс шаардлага хангахгүй байна.</p> <p>Иймд камерын үзүүлэлтүүдийг тусгай болон энгийн хэрэглээний хувьд ялгаж тогтоох, нэр томьёо, тодорхойлолтуудыг шинэчлэх, хэрэгжилтийг хангуулах, цаашилбал телехяналтын сүлжээний чанар, ашиглалтыг сайжруулах, улсын төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулах шаардлагатай байгаа юм.</p>
<p>Стандартын хамрах хүрээ /стандартаар юуг тодорхойлох, зайлшгүй тусгах, шинэчлэх шаардлагууд/</p>	<p>Телехяналтын камерын систем, удирдлагын төв, энгийн болон тусгай /төрийн тусгай чиг үүрэг хэрэгжүүлэгч байгууллага/ хэрэглээний шаардлагууд, нэр томьёо, тодорхойлолтууд</p>
<p>Стандартыг хаана мөрдөх</p>	<p>Барилга, орон сууц, гудамж талбай, иргэд, аж ахуйн нэгж, төрийн болон төрийн бус байгууллагуудын аюулгүй байдлыг хангах, теле хяналтын системийн сүлжээг төлөвлөх, байгуулах, ашиглалт, үйлчилгээ явуулах, шалгаж хүлээж авах, хяналт тавихад хамаарна.</p>
<p>Стандартаар уялдуулах хууль тогтоомж, үндэсний болон олон улсын стандартууд, бусад холбогдох баримт бичгүүд</p>	<p>Харилцаа холбоо болон барилгын салбарт мөрдөгдөж буй олон улсын болон үндэсний стандарт, норм дүрэм, зөвлөмжүүд, бусад холбогдох хууль, дүрэм журам, баримт бичгүүд, тэдгээрт тусгасан нэр томьёо, тодорхойлолтууд</p> <p>/Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хууль, Цагдаагийн албаны тухай хууль, Аж ахуй нэгжийн тусгай зөвшөөрлийн тухай хууль, MNS 27001:2009, MNS 6242-2:2011, MNS 5207:2011, MNS 5207:2002, MNS 5209 : 2002, MNS 2361 :1977, MNS 5207 : 2011, EN 62262, IEC 62262, ONVIF стандарт, NEMA стандарт гэх мэт/</p>